



**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2026 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

Зардал батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалтууд, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2.2 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.3, 8.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Дорнод аймгийн Хэрлэн сумын Хэрлэн гол орчмоор заарт хархны популяци дундах зоонозын өвчний холбогдлыг тогтоох тандалт судалгаа"-ны ажлыг удирдамжийн дагуу чанартай гүйцэтгэж ажиллахыг Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны Амьтан судлаач (Д.Батжав)-д, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны дарга (Х.Ариунболд)-д тус тус үүрэг болгосугай.

2. Батлагдсан удирдамжийн дагуу тандалт судалгааны зардлын 6,576,612 (Зургаан сая таван зуун далан зургаан мянга зургаан зуун арван хоёр) төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Болормаа)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны албаны дарга (У.Нямжаргал)-д даалгасугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.АМГАЛАНБАЯР